

МОНГОЛ, ОРОСЫН ХАРИЛЦААНЫ ШИНЭ ШАТ*С.Дамдинсүрэн**

Дэлхийн хүчирхэг том гүрэн ЗСБНХУ задарч, социалист хамтын нөхөрлөл гарснаар Монгол Улсын гадаад орчин үндсээр өөрчлөгдөн, тэдгээрийн шууд хараат байж бүх талын тусламж ивээлд нь дулдуйдсан монголын эдийн засаг өөрийгөө аваад явах чадавхигүй болохоо харуулж гүн хямралд автсан билээ. Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар байгуулагдсан үйлдвэрийн газрууд 1980-аад оны эцэс гэхэд Монголын үндэсний орлогын тэн хагасыг, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 56 хувийг үйлдвэрлэж байсан хийгээд Монголын эдийн засгийн 60 хувь нь ЗХУ-ын тусламж, нөлөөн дор хөгжиж байсан тэр нөхцөл байдал үгүйсгэгдсэн явдал уг хямралд хүчтэй нөлөөлсөн юм. Үүний хамт ЗСБНХУ-ыг өвлөн залгамжлагч болон үлдсэн ОХУ ч дотооддоо улс төр, эдийн засгийн эвдрэл хямралын ужигарсан бэрхшээлтэй тулгарч, монголыг тэтгэж байсан тэрхүү их гүрний үүрэг, нөлөөг орлох нөхцөл, боломжгүй байв. Манай улсын гадаад худалдааны бараа эргэлтэд урьд ЗСБНХУ 90 орчим хувийг эзэлж байсан бол энэ нь сүүлийн арваад жилд эрс уналтад орж, түүнд ОХУ-ын эзлэх хувийн жин гурав дахин буурсан үзүүлэлттэй /З.2001.7.9/ байгаа ганц баримтыг дурдахад л байдал тодорхой юм. Иймээс манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг хуучин системийн гажуудал, ачаа дарамтаас чөлөөлж, хоёр ард түмний сайн хөршийн олон зууны уламжлал, үнэт зүйлд тулгуурлан, орчин үеийн чиг хандлага, бодит нөхцөлд нийцүүлэн шинээр төлөвлшүүлэн хөгжүүлэх шаардлага зүй ёсоор дэвшигдсэн байна.

“Хүйтэн дайн” төгссөнөөр улс орнууд нээлттэй, хүмүүнлэг ардчилсан харилцааны зүг татагдан, сөргөлдөн тэмцэлдэгч хоёр туйлт тогтолцооноос олон туйлт тогтолцоонд шилжиж, олон улсын харилцааны шинж, агууллага, дэг журам, бүтэц шинэчлэгдэх өргөн боломж нээгдэв. Улс орнуудын харилцан хамаарал, харилцан шүтэлцээ гүнзгийрэн тодорч, интеграцичллын хүрээ өргөжин, улс хоорондын хоёр талын болон олон талын хамтын ажиллагааны ач холбогдол өсөж, агуулга, хэлбэр, механизм ч шинэчлэгдэж буй нь ХХ зууны төгсгөл, ХХI зууны

*С.Дамдинсүрэн - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

эхлэлийг тодорхойлогч чиг хандлага болов. Улс хоорондын харилцаанд анги бүлэглэлийн, эвсэл холбоотны, ах дүүгийн гэх зэрэг явцуу ангилалт үеэ өнгөрөөж, эрх тэгш, харилцан хүндэтгэх, тэнцвэрт байдал, итгэлцэл, түншлэх, олон тулгуурт зэрэг түгээмэл зарчмууд зонхилох болж байна.

Улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаа нь хоёр талын хүрээнээс тив, бус нутгийн хүрээнд шилжин харилцан хамаарал, харилцан шүтэлцээ өргөжин гүнзгийрэх тутам хамтран шийдвэрлэх, хүч бололцоогоо нэгтгэх асуудал олноор дэвшигдэж байна. Урьд нийгмийн болон системийн ялгаагаар тодорхойлогдож байсан олон зүйл эдүгээ газар зүйн, бүс нутгийн болон стратегийн түншлэлийн сонирхол, соёл иргэншлийн шалгуураар тодорхойлогдох болов. Урьд худалдаа, эдийн засгийн харилцаа, үйлдвэрийн хоршилт төрөлжилт системийн хүрээндэх худалдаа, хязгаарлагдмал шинжтэй бөгөөд дэлхийн зах зээлийн нийтлэг харилцаанаас хөндий салангид байсан бол эдүгээ тэр нь бүс нутгийн хэмжээнд, хүрээлэн буй орчин, үйлдвэрлэх хүчний хөгжил, байршил, капиталын бөөгнөрөл, шинжлэх ухаан, технологийн дэвшил зэрэг олон нийтлэг хүчин зүйлээр нөхцөлдөн глобалчиллын түгээмэл хандлагыг тусгасан шинэ нөхцөлд зохицон хөгжих болов. Дэлхийн хамтын нийгэмлэгийг нэгтгэн төлөвшүүлэх олон улсын байгууллагууд, шинэ механизм, бүс нутгийн хэмжээний банк, санхүү, аж үйлдвэрийн нэгдэл холбоонууд үүсч, үүрэг нөлөө нь өсөн нэмэгдэж байна. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк ОУВС, дэлхийн худалдааны байгууллага зэрэг нөлөө бүхий хүчтэй байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ бүс нутаг, тив дэлхийг хамрах болов.

1991 оны эхээр Олон улсын санхүүгийн дундын аж ахуй, Олон улсын хөгжлийн нэгдэлд гишүүнээр элсэх тухай Монгол улсын хууль гарсны дараа Монгол Улс /1991 онд/, ОУВС, Дэлхийн банк, 1992 онд Дэлхийн гаалийн байгууллага, Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллага, 1996 онд олон улсын далайн тээврийн байгууллага, 1997 онд Азийн хөгжлийн банк ба дэлхийн худалдааны байгууллагуудад удаа дараалан элсэн орсон явдал тив бүс нутгийн болон дэлхийн эдийн засгийн интеграцид оролцох, глобалчиллын чиг хандлагыг баримжаалан хөгжихөд байнга нөлөөлөгч хүчин зүйл болсон юм. Эрх зүй, хүмүүнлэгийн болон зохион байгуулалтын үүрэг, нөлөө нь өргөн далайцтай болж буй НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, байнгын төлөөлөгчдийн газруудын үйл ажиллагаанд Монгол улс аялдан дагалдагч бус биеэ даасан субъектын хувьд идэвхтэй оролцох болов. Монгол Улс гадаад бодлогын ангич, үзэл сурталч зарчмыг тэргүүлэх

байранд тавьсан номлол хийгээд хөршүүд, түншүүдэд ялгавартай ханддаг хуучин сэтгэлгээнээс татгалзаж, бүх улс оронд адил тэгш хандах зарчмыг тодорхойлсон 1992 оны Шинэ үндсэн хуулийнхаа заалтыг / 1.5/ удирдлага болгон, Ази, Номхон далайн бүс нутаг, түүний хоёр салбар бүс-Төв Ази, Зүүн хойт Азийн уулзварт, ОХУ, БНХАУ гэсэн хоёр том гүрэнтэй хөрш оршдог газар зүйн байрлалын онцлогийг харгалзан гадаад бодлогын үзэл баримтлалаа боловсруулан мөрдөж байгаа билээ. Ардчилсан шинэчлэлийг тууштай гүнзгийрүүлэх, зах зээлийн харилцааг эерэгээр төлөвшүүлэх, хүмүүнлэг ардчилсан иргэний нийгмийг цогцлуулан хөгжүүлэх гадаад таатай орчинг бүрдүүлэх эрх ашигт болон, дэлхийн янз бүрийн бүс нутаг, улс орнуудын харилцааны шинэ чиг хандлагад нийцсэн уг үзэл баримтлалд ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаатай байх явдлыг гадаад бодлого, гадаад харилцааны тэргүүлэх чиглэл хэмээн заасан байна.

Монгол, Оросын найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа нь түүхэн сорилт, цаг үеийн шалгуурыг давж нийгмийн дэвшилд байнга нөлөөлөгч чадавхиа нээсээр ирсэн баялаг уламжлалтай билээ. Энэхүү найрамдал, хамтын ажиллагаа нь хоёр орон, хоёр ард түмэн хөршийн ёсоор зэрэгцэн амьдрах бодит нөхцөл байдал тус тусын эрх ашиг, зорилго, эрмэлзлэлийн нийтлэгт тулгуурласны ачаар ямагт бүтээгч, шинэчлэгч чанарыг өөртөө агуулсаар иржээ.

XX зууны Монгол, Оросын түүхэн харилцаанд агуулга, далайц хэмжээгээрээ, цаг хугацаа, орон зайгаараа ч гол байр эзэлсэн социалист нийгэм байгуулах туршилт эцсийн дүнд амжилтгүй төгссөн ч хоёр ард түмний соёл иргэншлийн харилцан нөлөөллийн хүрээнд уламжлагдан хөгжих үнэт зүйл хуримтлагдсаар байсныг үгүйсгэх аргагүй. Нийгэм улс төрийн хоёр системийн сөргөлдөөн, дайн, хувьсгалын нарийн эдрээтэй нөхцөлийг хамтдаа туулсан Монгол, Оросын харилцааны хөгжил, Зөвлөлт Холбоот Улсын тал бүрийн дэмжлэг, тусламжийн эерэг нөлөөгөөр Монгол Улс тусгаар тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулж, эдийн засаг, соёлоо хөгжүүлж, өвөрмөц соёл иргэншлээ хадгалж чадсан төдийгүй түүнийг шинэ агуулгаар баяжуулж, тэргүүний орнуудаас алслагдсан хоцрогдлоо мэдэгдэхүйц хэмжээгээр багасгаж чадсан билээ. Тус хоёр улс өнөөгийн дэлхийн хөгжлийн чиг хандлагад хөл нийлүүлж, хөгжингүй ардчилал, зах зээлийн харилцаа бүхий, бүх улс оронтой нээлттэй байх хөгжлийн шинэ загварт шилжих эдийн засаг материалын болон оюуны зохих чадавхитай болохоо ч харуулсан юм.

Хоёр улсын харилцааны эрх зүйн үндсийг хамтын

ажиллагааныхаа шилдэг уламжлал, олон улсын харилцааны бодит нөхцөл, хандлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулахад 1991-2000 онд Монгол Улс, Оросын Холбооны Улсын төр, засгийн удирдлагын дээд түвшинд хийсэн уулзалтууд, шинээр байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд чухал үүрэг гүйцэтгэжээ.

1991 оны хоёрдугаар сард БНМАУ, ЗСБНХУ-ын худалдаа эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдсанаар нээлттэй эдийн засгийн бодлого, зах зээлийн харилцааны нөхцөл, шаардлагыг тусгасан харилцаа, хамтын ажиллагааны шинэ механизмд шилжих алхам хийгджээ.

Хоёр орны холбогдох байгууллага, газрууд, хоорондоо цоо шинэ зарчмын үндсэн дээр гэрээ, хэлэлцээр байгуулах бололцоо нээгдэж 1991 оны эхнээс харилцан нийлүүлж буй бараа, шилжүүлэн өгөхөд бэлэн болсон барилга, байгууламжууд, техникийн дэмжлэг, мэргэжилтний цалин зэрэг нэлээд төрлийн төлбөр тооцоог чөлөөтэй хөрвөх валютаар, дэлхийн зах зээлийн үнэ, ханшаар хийж гүйцэтгэх болсон байна. Энэ үеэр худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Оросын Засгийн газар хоорондын комисс байгуулах тухай тохиролцсон нь энэ чиглэлийн хамтын ажиллагааны байнга үйлчлэх нөлөө бүхий механизмыг бүрдүүлэх үндэс болсон билээ.

1991-2000 он бол хоёр орны харилцааны агуулга, хэлбэр, шинж чанар, арга, механизмыг бүх талаар шинэчлэх үе байсан учир төр, засгийн дээд удирдлагын харилцан уулзалт, яриа, хэлэлцээр тогтмолжиж, зөвхөн хоёр улсын ерөнхийлөгчид, Их хурал ба төрийн думын дарга нар, Ерөнхий сайд нарын түвшинд л 10 гаруй удаа зохиогджээ.

1993 онд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат ОХУ-д албан ёсны айлчлал хийж ерөнхийлөгч Б.Ельцинтэй хоёр орны харилцааны өргөн хүрээг хамарсан асуудал хэлэлцэж “Монгол Улс, Оросын Холбооны улсын найрсаг харилцаа хамтын ажиллагааны тухай гэрээ” /4.1993. 2 дугаар сар. №5/ байгуулсан билээ. Энэ гэрээ нь олон арван жилийн турш хэвшин тогтсон харилцааны хуучин загварыг халах, ардчилал, шинэчлэлийн үзэл санаа, олон улсын харилцааны нийтлэг ёс зүйг шингээсэн шинэ зарчмуудыг төлөвшүүлэх хамтын чин эрмэлзлэл, хүчин чармайлтыг тусгаснаараа хоёр улсын харилцааны шинэчлэгдэн хөгжих эрх зүйн үндсийг тавьсан юм. Тухайлбал, хоёр улс “Өөр хоорондын харилцаандаа бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг

хүндэтгэх, адилхан бүрэн эрхтэй байх, хүч үл хэрэглэх буюу хүчээр сүрдүүлэхгүй байх, хилийн халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, хүний эрх болон үндсэн эрх чөлөө, улс түмний тэгш эрх, хувь заяагаа өөрсдөө шийдвэрлэх эрхийг хүндэтгэх, хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлэх, сайн хөрш, түншийн ёсоор хамтран ажиллах зарчмуудыг удирдлага болгоно” /4.1993.2 дугаар сар.№5/ гэж харилцааныхаа эрх зүйн үндсэн зарчмыг тодорхойлсон байна. Мөн хоёр орны парламент болон төрийн бусад сонгуульт байгууллагуудын хооронд хэлхээ, холбоо хөгжүүлэхийг онцлон заажээ. Үүнтэй холбогдуулан “Б.Ельцин “Эдүгээ бид ах дүүгийн ивээлийн ёсоор бус, харин олон улсын харилцааны түгээмэл зарчимд үндэслэн эрх тэгш, бүрэн эрхт, тусгаар тогтносон байдлыг хүндэтгэх ёсоор хоёр талын харилцаагаа хөгжүүлэх юм. Өөрөөр хэлбэл бид харилцан ашигтай, бие биеийн үндэсний эрх ашгийг хүндэтгэх зарчмыг гол болгоно” /3.1993.1.22/ гэж онцлон тэмдэглэжээ. Хоёр ерөнхийлөгч 1930-1940 оод оны үеийн улс төрийн хэлмэгдүүллийн талаар хамтарсан мэдэгдэл /3.1993.1.226 №3/ гаргасан нь Монгол, Оросын харилцааны өнгөрсөн түүхийн эмгэнэлт гажуудал, “Цагаан толбыг” даван туулж, түүхэн үнэнийг сэргээх, харилцан итгэлцэл, хүндэтгэл, хүмүүнлэгийн нандин уламжлалыг хамгаалан хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтой болсон юм. Уг гэрээнд “Талууд улс төр, эдийн засаг, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан, техник, эрүүлийг хамгаалах, батлан хамгаалах, аюулгүй байдал, экологи, зам тээвэр, харилцаа холбоо, мэдээлэл, хүмүүнлэгийн болон бусад салбарт эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтвортой, урт хугацааны үндсэн дээр хөгжүүлнэ” /4.1993.№5/ гэсэн нь хоёр орны харилцааны нийтлэг сонирхол, өргөн цар хүрээг тусган илэрхийлсэн байна.

1994 онд ОХУ-ын Төрийн Думын даргын урилгаар Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй Монголын парламентын төлөөлөгчид Москвад айлчилж хоёр орны хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд чиглэсэн Меморандум болон парламентын бүлгүүдийн хоорондын хамтын ажиллагааны тухай протоколд гарын үсэг зурсан байна. 1995 онд ОХУ-ын төрийн Думын дэд дарга А.Д.Венгеровский тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав. 1996 онд ОХУ-ын Төрийн Думын дарга Г.М.Селезнев тэргүүтэй Оросын Төрийн Дум ба Холбооны хурлын төлөөлөгчид Монголд айлчилсан нь парламент хоорондын харилцааг идэвхжүүлэхэд чухал үйл явдал болсон бөгөөд одоо энэхүү харилцаа тогтмолжин үргэлжилж хамтын ажиллагааны агуулга, хүрээ жилээс жилд өргөжиж байна.

1995 оны дөрөвдүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай ОХУ-ын Засгийн газрын дарга В.С.Черномырдины урилгаар Москвад айлчилж өргөн хүрээтэй хэлэлцээр хийж олон чухал баримт бичигт гарын үсэг зуржээ. Үүнд: Шинжлэх ухаан ба соёлын хамтын ажиллагааны тухай, иргэд харилцан зорчих тухай, шуудан ба цахилгаан холбооны салбарт хамтран ажиллах тухай, ус цаг уурын ба байгаль орчны хамгаалалтын салбарын хамтын ажиллагааны тухай баримт бичгүүд болон 1995 оны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны протокол зэрэг арваад баримт бичиг орсон байна. Мөн онд ОХУ-ын Засгийн газрын дэд тэргүүн О.Д.Давыдов Монголд айлчилж П.Жасрайн Москвад айлчлах үеэр тохиролцсон асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд хэлэлцээрүүд хийжээ./3.1995.12.2/.

Хоёр орны хамтын ажиллагаа өгч, улс төрийн яриа хэлэлцээг идэвхжүүлэхэд хоёр улсын гадаад харилцааны сайд нарын хэд хэдэн удаагийн харилцан айлчлал, хоёр улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хооронд шинээр тогтсон харилцаа, тэдгээрийн удирдлага, санхүү, эдийн засгийн, БХ-ын болон хууль зүйн зэрэг төрийн сайд нарын түвшинд сүүлийн жилүүдэд зохиогдож буй, уулзалт, хэлэлцээрүүд чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал 1996 оны намар ОХУ-ын Гадаад Хэргийн Яамны тэргүүн Евгений Примаковын Монголд хийсэн айлчлалыг онцлон тэмдэглэвэл зохилтой. Тэр үед гарын үсэг зурсан Монгол Оросын хамтарсан албан мэдээнд хоёр талын харилцааны гэрээ эрхийн үндсийг цаашид шинэчлэн бэхжүүлэхийг харилцан сонирхож байгааг нотлоод эдийн засгийн хамтын ажиллагааны асуудалд онцгойлон анхаарах, гадаад эдийн засгийн харилцааг олон талын шинжтэй болгохын тулд байгаа бүхий л бололцоо, нөөцөө ашиглах эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлжээ. Тэрхүү баримтад хоёр орны хоорондын худалдааны эргэлтийн хэмжээ буурсан уналтыг зогсоож аажмаар өсөх хандлагатай болгож чадсаныг тэмдэглээд Монгол, Оросын худалдааны чөлөөт бүс байгуулах санаачилга дэвшүүлжээ.

Монгол, Оросын улс төрийн харилцаа идэвхжиж байгаагийн үр дүнд уг харилцааны шинж чанар, агуулга тууштай шинэчлэгдэж, хамтын ажиллагааны шинэ зарчим, шинэ механизмууд бий болж, олон улсын харилцааны хэм хэмжээнд нийцсэн эрх зүйн үндэс амжилттай бүрэлдэж байна. 1999 онд Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабанди ОХУ-д ажлын айлчлал хийсэн явдал хоёр улсын харилцааны шинэ зуунд чиглэсэн хамтын ажиллагааны асуудлуудыг тодорхойлох эхлэлийг тавьсан юм.

2000 оны 11 дүгээр сард ОХУ-ын ерөнхийлөгч В.В. Путин Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар манай оронд айлчилсан нь Монгол, Оросын баялаг уламжлалт харилцааны түүхэнд шинэ хуудас, шинэ төлөвийг нээсэн том үйл явдал болов. Хоёр ерөнхийлөгч Монгол Улс, ОХУ-ын харилцааны өнөөгийн байдлыг бүрэн хэмжээнд тал бүрээр үнэлэн цэгнэж, шинэ XXI зууны хамтын ажиллагааны чиглэл, агуулга, төлөвийг олон улсын харилцааны өргөн цар хүрээ, нийтлэг хандлагатай холбон тодорхойлсон чухал баримт бичиг-"Улаанбаатарын тунхаглал"-д /5.2000.11.15.№212/ гарын үсэг зурсан юм. "Улаанбаатарын тунхаглал" бол 1993 оны гэрээгээр тодорхойлсон хоёр улсын харилцааны зарчмуудыг дахин нотлохын хамт сүүлийн жилүүдийн туршлага, дэлхий дахинд болон Ази тивд бүрэлдэж байгаа нөхцөл байдал, үүсэн гарч буй асуудлын үүднээс хандсан шинэ санаа, дүгнэлтүүдээр баяжуулав. "Улаанбаатарын тунхаглалд" дэлхий дахинаа олон туйлт бүтцийг төлөвшүүлэх, Ази тивд улс хоорондын харилцааг эвсэл бүлэглэлгүй хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллах байр сууриа тодорхойлсон нь зарчмын ач холбогдолтой юм.

Тэрхүү баримт бичигт хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, худалдааг чөлөөтэй болгон өргөжүүлэх, төмөр замын тариф, гаалийн татвар, бусад хураамжийг хөнгөлөлттэй тогтоох асуудлыг 2001 онд багтаан шийдвэрлэх, "Эрдэнэт", "Монголросцветмет", "УБГЗ" зэрэг хамтарсан томоохон үйлдвэрүүдийг шинэчлэн тоноглох, өмчийн янз бүрийн хэвшлийн үндсэн дээр хамтарсан үйлдвэрүүдийг шинээр байгуулах, хоёр улсад явагдах хувьчиллын төслүүдэд хоёр орны аж ахуйн субъектүүдийг оролцуулах мэтээр харилцан хөрөнгө оруулалт хийх зэрэг одоо хэрэгжиж эхлээд байгаа тодорхой ажил хэрэгч заалт олныг дурдаж болох юм. Түүнчлэн аж үйлдвэрийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах, Монгол Улсад Орос Улсаас түлш, эрчим хүч нийлүүлэх явдлыг худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны жил бүрийн протоколын үндсэн дээр тогтвортой болгох, Монголын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд харилцан ашигтай хамтын ажиллагааг сэргээх зэрэг манай улсын үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх эрх ашигт нийцсэн олон тодорхой зорилт уг баримт бичигт бас тусгагджээ. Хоёр улсын бүс нутгийн болон хил орчмын хэлхээ холбоог дэмжиж цаашид өргөтгөн гүнзгийрүүлэх, түүний эрх зүйн үндсийг боловсруулахад хамтын чармайлт тавихыг тунхаглалд бас цохон тэмдэглэжээ. Улс орны дотоодод харилцан нөхөх чадвартай эдийн

засгийн бүтцийг бүрдүүлэхэд хамтын ажиллагааны боломжийг чиглүүлэх, үр ашиг нь алдагдах буюу буурахад хүрч буй үйлдвэрүүдээ юуны өмнө өндөр технологитой гадаадын салбаруудтай хорших шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг ч заасан байна.

Хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг Зүүн хойт Азид төлөвшиж байгаа бүс нутгийн хамтын ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж XXI зуунд хандсан бүс нутгийн хамтын ажиллагааны томоохон төслүүд болох хий, газрын тос дамжуулах хоолой, цахилгааны шугамыг барьж байгуулахад их ач холбогдол өгч тэдгээрийг хэрэгжүүлэхэд эдийн засаг, газар зүйн хүчин зүйлийг харгалзан Монгол Улс оролцохыг Оросын тал дэмжиж байна гэж Тунхаглалд заажээ. Оросоос Зүүн хойт Ази руу эрчим хүч дамжуулах хэрэгцээ өсч байгаа өнөө үед түүнийг Монголын нутгаар дайруулах нь хэмнэлттэй бөгөөд бүс нутгийн интеграцыг хөгжүүлэх чиг хандлагад нийцэх болно.

Ази, Номхон далайн бүс нутагт, улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улс идэвхтэй оролцож болох нэг чухал чиглэл бол тээврийн салбар мөн билээ. Тээврийн салбарт хамтран ажиллах нь Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн орнуудын хоорондын хамтын ажиллагаанд төдийгүй Европ болон Ази, Номхон далайн бүс нутгийн хоорондын тээврийн чиглэлийг оновчтой, үр өгөөжтэй болгоход их ач холбогдолтой юм. Энэ үүднээс Монголын төмөр зам, Сибирийн гол төмөр замыг ашиглах сонирхлыг хөхүүлэн дэмжих, Монголын мянганы замын бүтээн байгуулалтанд хөрш орнууд болон бүс нутгийн хамтын ажиллагааны хүчин зүйлийн оролцоог нэмэгдүүлэх талаар хүч чармайлтаа нэгтгэх нь чухал юм. Иймээс ч Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хоорондын тээврийн асуудлаар ерөнхий хэлэлцээр байгуулах талаар явагдаж ирсэн гурван талын мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалтыг их ач холбогдолтойд үзэж түүнийг үргэлжлүүлэхээр тохиролцсоныг Монгол, Оросын Улаанбаатарын Тунхаглалд онцлон тэмдэглэжээ.

В.Путины монголын дээд удирдлагуудтай хийсэн яриа, хэлэлцээрүүд, ялангуяа Улаанбаатарын тунхаглалын үзэл санаа, ОХУ Монголыг зөвхөн Азид төдийгүй, нийт олон улсын хэмжээн дэх өөрийн чухал түнш гэж үздгийг батлан харуулав. “Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд танай орон онцгой байр суурь эзэлдэг” гэж В.Путин онцлон тэмдэглэж байв. НҮБ болон Олон улсын бусад байгууллагуудад стратегийн тогтвортой байдлыг хангах, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх талаар ОХУ-ын гаргасан санал санаачилгуудыг Монгол Улс дэмжиж

ирсэн бөгөөд 2000 онд цөмийн зэвсэг бүхий таван гүрэн Монгол Улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусыг дэмжсэн мэдэгдэл гаргахад Оросын тал идэвхтэй дэмжлэг үзүүлсэн билээ. 2000 оны 6 дугаар сарын 28-нд Оросын Холбооны Улсын ерөнхийлөгчийн баталсан ОХУ-ын гадаад бодлогын шинэ үзэл баримтлал /7 с.3-14/ Оросын гадаад бодлогын чиглэлүүд болон үндсэн зарчмуудыг тодорхой ойлгож Оросын эрх ашигтай өөрийн эрх ашгийг улам сайн уялдуулах боломж олгож байгаа бөгөөд тухайлбал, Монголын хувьд онцгой ач холбогдол бүхий шинэ чиглэл, заалт цөөнгүй байгаа ажээ. Үүнд: Оросын хилийн шугамын дагуу сайн хөршийн бүс байгуулах, гадаад орнуудтай эрх ашгийн зохицол ба зөвшилцөлд хүрэх, Оросын гадаад бодлогод Азийн ач холбогдол чухал бөгөөд улам өсөн нэмэгдэж байгааг нэг талаар, ОХУ энэхүү эрчимтэй хөгжиж буй бүс нутагт шууд харъяалагддаг, нөгөө талаар Монгол, Оросын хилд ойрхи нутаг Сибирь, Алс Дорнодын эдийн засгийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг тусган илэрхийлсэн заалтуудыг дурдаж болох юм./7.4/

Ийнхүү Монгол, Оросын харилцааны сааралт, тогтонги үеийг гэтлэн давж түүнийг цаашид хөгжүүлэх эрх зүйн болон улс төр, дипломатын бат тогтвортой үндэс суурьтай болов.

Хоёр улсын харилцааны шинэ нөхцөл байдалд зохицсон үр ашигтай механизмыг бүрдүүлэхэд Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын үүрэг, ач холбогдол жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Комиссын анхдугаар хуралдаан 1992 оны 5,6 дугаар сарын заагт Улаанбаатар хотноо болж Монгол Улсын Засгийн газрын ерөнхий сайд Д.Бямбасүрэнгийн 1991 оны ажлын айлчлалын үеэр хэлэлцэн тохиролцсон ажлын явц байдал, хоёр улсын харилцааны хууль эрхийн үндэс, ОХУ-аас Монгол Улсын авсан зээлийн өрийг зохицуулах, харилцан бараа нийлүүлэхтэй холбогдсон өргөн хүрээтэй асуудал хэлэлцэж олон чухал тохиролцоонд хүрсэн байна. Тухайлбал, хоёр тал харилцан зохицуулж нийлүүлэхээр баримжаалсан жагсаалтад орсон барааны төлбөр тооцоог чөлөөт валютаар, үйлдвэр, компани, аж ахуйн бусад нэгжүүдийн хооронд болон дээрх жагсаалтад тусгагдаагүй барааны төлбөр тооцоог чөлөөт валют, үндэсний валют, төлбөрийн бусад хэрэгслээр гүйцэтгэж байхаар тогтсон нь зах зээлийн харилцаанд шилжиж буй үеийн хэрэгцээ шаардлагыг тусгасан байна. Урьд жилүүдэд хуучин ЗХУ-ын хүч хөрөнгө, техникийн туслалцаатайгаар барьж гүйцээгүй үлдсэн барилга байгууламжуудыг үргэлжлүүлэн, тоног

төхөөрөмж нийлүүлэхэд ОХУ 38,7 сая ам.долларын зээл олгохоор болжээ. Мөн 1991-1995 онд Монгол Улсаас Орос Улсад төлөх урсгал өрийг 2000 он хүртэл хүү бодохгүй хойшлуулахаар шийдвэрлэсэн байна. Комисс хоёр талын харилцааны хууль эрхийн үндсийг боловсронгуй болгох, хил орчмын болон аймаг, мужууд, үйлдвэр компани, пүүс хоршоо, аж ахуйн нэгжүүдийн хоорондох харилцааг цаашид өргөжүүлэхэд бүх талын туслалцаа үзүүлэхээр тохиролцож анхдугаар хуралдааны протокол, 1992 онд худалдаа, эдийн засгийн талаар хамтран ажиллах протокол, төлбөрийн хэлэлцээр гэсэн гурван баримт бичигт гарын үсэг зуржээ.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссын хүрээнд хамтын ажиллагааны үр ашигтай механизмыг бий болгох талаар жилээс жилд ахиц өөрчлөлт гарч байгааг түүний удаа дараагийн худалдаа харуулж байна. Үүнд 1993 оны 7 дугаар сард Красноярскт болсон комиссын II хуралдаан, дээд хэмжээний уулзалтаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх, салбар, субъектүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүдийг бий болгох асуудлууд хэлэлцэж тодорхой шийдвэрүүд гаргажээ. Энэ хуралдааны үеэр хоёр талын ажил хэрэгч хүмүүсийн анхны уулзалтыг зохион байгуулсан нь хамтын ажиллагааны үр ашигтай хэлбэр болон уламжлагдаж оролцогчдын хүрээ бүс нутгуудыг хамран өргөжих хандлагатай болов. Мөн оны 11 дүгээр сард хоёрдох тийм уулзалт Улаанбаатарт болсон бол энэ нь жил бүр тогтмолжин 1999 онд Монгол Оросын бизнес эрхлэгчдийн уулзалт Москвад гурав, Екатеринбургт нэг, 2000 онд Уфад нэг удаа зохион байгуулагдаж тэдгээрт Оросын талаас 150, Монголын талаас 100 пүүс компанийн төлөөлөгчид оролцсон байна.

1995 оны 2 дугаар сард болсон худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын III хуралдаан хоёр орны харилцааны шинэ загварыг аж ахуйн амьдралын бүх түвшинд эрчимтэй хамтын ажиллагаа явуулах замаар өргөтгөн боловсронгуй болгон сайжруулах асуудлыг хэлэлцснээрээ онцлог юм. Энэ мэтээр Засгийн газар хоорондын энэхүү комиссын хуралдаан бүр өөрийн гэсэн өвөрмөц шийдлээрээ хоёр улсын хамтын ажиллагааны хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсаар ирснийг дараа дараагийн хуралдаанууд тодорхой харуулав.

1998 оны гуравдугаар сард Улаанбаатарт хуралдсан тус комиссын VI хуралдаан хоёр улсын хамтарсан Эрдэнэт,

Монголросцветмет нэгдэл, Улаанбаатарын төмөр зам зэрэг хамтарсан үйлдвэрийн газруудын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээний тухай хэлэлцсэн нь их ач холбогдолтой болсон юм. Мөн Засгийн газар хоорондын комиссын хүрээнд хоёр улсын хооронд худалдааг либеральчлах комисс байгуулах шийдвэр гаргасан байна. Худалдааг либеральчлах ажлын хэсгийн хуралдааныг 1999 оны 10 дугаар сард Москвад хийсэн нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, идэвхжүүлэх бас нэг шинэ механизм бий болсныг харуулав. Үү хуралдаан бүс нутгийн ба хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын дүрмийг баталж Монгол, Оросын хооронд бүс нутаг ба хил орчмын хамтын ажиллагааны програмыг гүйцээн боловсруулах, батлах талыг түргэтгэх зэрэг чухал тохиролцоонд хүрчээ.

Дээрх гурван том хамтын үйлдвэрийн газраас гадна Монголд Оросын хөрөнгө оруулалт бүхий олон тооны аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн дотор Оросын талын 100%-ийн хөрөнгө оруулалт бүхий “Зарубежстрой”, “Бурводстрой”, “Золотой Восток-Монголия”, хамтарсан “Инкон”, “Эрдэнэт строй” зэрэг хэд хэдэн компани орж байна. Эдгээр нь жилд 25,0 сая ам.долларын барилга угсралтын ажил гүйцэтгэдэг ажээ.

Оросын ерөнхийлөгч В.Путины Монголд айлчлахын өмнөхөн Улаанбаатарт болсон худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын VIII хуралдаан хоёр орны худалдаанд оролцогчдод улам илүү таатай журам нөхцөл бүрдүүлэх асуудалд ихээхэн анхаарал тавьжээ. Тус хуралдаан Оросын нутаг дээр Монголын ачаа тээврийн гааль, төмөр замын тарифыг бууруулах, Монголоос Орост мах нийлүүлэх, Монгол, Оросын хил дээр нэвтрүүлэх боомтуудыг төвхнүүлэн байгуулах зэрэг чухал асуудлууд хэлэлцжээ. Тухайлбал, Монголын урсгал өрийг Оросын зах зээлд эрэлт хэрэгцээ бүхий бараагаар барагдуулах асуудлыг авч үзсэн юм. Эдгээр нь эдийн засгийн асуудлуудыг дээд түвшинд хэлэлцэх бэлтгэлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэжээ.

2001 оны 12-р сард Москвад болсон уг комиссын IX хуралдаан өмнөх хуралдааны шийдвэр, хэлэлцээрүүдийн биелэлтийг дүгнэхийн хамт, ялангуяа бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны явц, “Сибирийн хэлэлцээ” нийгэмлэгтэй хамтран ажиллах тэргүүлэх чиглэл, дэд бүтцийн салбарт хамтран ажиллах талаар хэд хэдэн протоколд гарын үсэг зуржээ. “Сибирийн хэлэлцээр” нийгэмлэгтэй хамтран ажиллахдаа бүс нутаг, хил орчмын үйл ажиллагаатай уялдуулахыг чухалчлан заажээ.

Хил орчмын бүс нутаг, субъектуудын харилцаа Монгол, Оросын харилцаанд чухал байр эзлэх болов. Хоёр улс зах зээлийн харилцаанд шилжин, аж ахуйн шинэчлэл явагдаж, эдийн засагт төрийн бүс хэвشلүүд зонхилох болсон шинэ нөхцөлд хил орчмын буюу янз бүрийн бүс нутаг, субъектуудын хоорондын шууд харилцааны ач холбогдол улам өсөж байна. Оросын Холбооны Улс субъектуудын гадаад хэлхээ холбоог зохицуулах механизмыг боловсронгуй болгох зорилгоор Гадаад Хэргийн яамныхаа дэргэд Олон улсын болон гадаад эдийн засгийн харилцааны асуудлаар холбооны субъектуудын зөвлөлдөх Зөвлөл гэдгийг байгуулан ажиллуулжээ.

Хил орчмын, бүс нутгийн , субъектуудын гадаад харилцааг зохион байгуулах талаар Монголын Засгийн газар ч хоёр орны бүс нутгийн эдийн засгийн сонирхлыг үр ашигтай уялдуулан зохицуулах, төр улсын болон орон нутгийн статусын хэм хэмжээний хүрээнд хоёр улсын хууль дүрмийн дагуу чөлөөтэй ажиллах нөхцөл бүрдүүлэх чиглэлээр хүчин чарайлт тавьж байгаа билээ. Энэ талын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс суурийг бүрэлдүүлэхэд 1992 оноос хойш байгуулагдсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн ба соёлын хамтын ажиллагааны тухай хоёр талын олон арван хэлэлцээр чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Хоёр улсын 3500 гаруй км урт хил, үйлдвэр, аж ахуйн цогцолборууд, түүхэн ёсоор бүрэлдсэн харилцан хамаарал, олон жилийн хамтын ажиллагааны туршлага, Оросын олон яам, газар, үйлдвэр, аж ахуйнуудын төлөөлөгчдийн Монголд удаан хугацаагаар ажиллаж байсан уламжлал хийгээд Оросын мэргэжилтнүүдийн Монголын зах зээлийн тухай мэдлэг, хувь хүмүүсийн холбоо хэлхээ, харьцангуй хямд, чанар найдвартай Оросын өргөн хэрэгцээний бараанд дассан монголчуудын эрэлт, Монголын мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн, уул уурхайн нөөцөд түшиглэсэн Оросын үйлдвэр, аж ахуйн газрууд бол бидний хамтын үнэт зйлс билээ. Мөн хоёр орны соёл, боловсрол, шинжлэх ухааны харилцан баяжсан өв уламжлал иргэд хоорондын харилцаа зэрэг Монгол, Оросын хил орчмын, бүс нутгийн, субъект хоорондын эрчимтэй хамтын ажиллагааны үндэс суурийг бататган бүхэлд нь тухайлбал Монгол дахь Оросын, Орос дахь Монголын сонирхлын хүрээг улам тэлж, хоёр орны харилцан хамаарал, харилцан шүтэлцээг өргөтгөн гүнзгийрүүлэх чухал хүчин зүйл болж байна.

Орос дахь Монголын хил орчмын болон бүс нутгийн гол түншүүд

гэвэл Буриад, Тува, Алтайн бүгд найрамдах улсууд, Эрхүү, Чит мужууд зэрэг айл зэргэлдээ нутгуудыг нэрлэж болно. Нэлээд алслагдсан нутгаас Халимаг, Татар, Саха /Якут/-ын бүгд найрамдах улсууд, Новосибирск, Кемеров, Свердлов мужууд орж байна. Монгол нь “Сибирийн хэлэлцээр”, “Байгалийн эдийн засгийн хамтын нөхөрлөл” хэмээх аж үйлдвэр-санхүүгийн нийгэмлэгүүдтэй холбоо тогтоох хамтран ажиллахад анхаарч байгаа билээ. 2002 оны 9 дүгээр сарын 16-20-нд Эрхүү хотноо болсон “Байгалийн эдийн засгийн чуулга уулзалтанд Улсын Их хурлын дэд дарга Ж.Бямбадорж тэргүүтэй төлөөлөгчид оролцсон үүний нэг нотолгоо мөн. “Оросын холбооны субъектууд” монголоор дамжин Хятад ба АНД бүсийн бусад орнуудтай хил дамжсан холбоо хөгжүүлэх бололцоотой юм.

Монгол, Оросын хил орчмын бүс нутаг, субъект хооронд хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд сүүлийн жилүүдэд Эрхүү мужийн амбан захирагч Ю.А.Ножиков /1996 он/, Б.А.Говорин /1999 он/, Эрхүү хотын мэр В.В.Якубовский /1999/, Кемеров мужийн амбан захирагч А.Г.Тулеев /2000, 2001/, БНБуриад Улсын Ерөнхийлөгч Л.В.Потапов /1999/, БН Саха /Якут/ улсын ерөнхийлөгч М.Е.Николаев /1993 он/, Свердлов мужийн амбан захирагч Э.Э.Россел /1996 он/, БНТува улсын ерөнхийлөгч Ш.Д.Ооржак /1995 он/, Чита мужийн захирагч Р.Ф.Гениатулин /2001/ нарын тэргүүлсэн төлөөлөгчид Монголд хийсэн айлчлал, яриа хэлэлцээрүүд их үүрэг гүйцэтгэв. 1991 оны 2 дугаар сард Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол, Халимагийн эдийн засгийн хамтын ажиллагааны Тунхаглал нь тус хоёр орны эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлжээ. Монгол ба БН Алтай Улсын хооронд шууд харилцаа хөгжүүлэх зорилго бүхий харилцан ойлголцох тусгай Протоколд 1993 оны 4 дүгээр сард гарын үсэг зурснаас хойш хоёр талын харилцааг сэргээн зохицуулах, янз бүрийн түвшинд төлөөлөгчид солилцох, үйлдвэр, ХАА-н бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, Чуйскийн авто дам дахь Тошинт-Цагааннуурын шалган нэвтрүүлэх цэгийн статусыг тогтоох зэрэг хамтын ажиллагаа идэвхжүүлэх олон чухал алхмууд хийгдэж шинэ шинэ хэлбэрүүд эрчимтэй хөгжих болов. Ялангуяа Монголын баруун бүсийн аймгууд, Алтайн БН Улсын хооронд нэлээд өргөн хүрээний хамтын ажиллагаа тогтжээ.

Монгол, Оросын бүс хоорондын хамтын ажиллагааны хэтийн төлөв бүхий чиглэлүүдэд геологийн ба уул уурхай, аж үйлдвэр зэрэг

уламжлалт салбараас гадна Монголын нутагт хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах хамтарсан үйлдвэрүүд байгуулах, урьд зөвлөлтийн зээлийн хөрөнгөөр эхэлсэн барилга байгууламжийг гүйцээж барих, аж үйлдвэрийн объектуудыг ашиглалтанд оруулах, урьд нийлүүлсэн хөдөө аж ахуйн болон бусад техникийн засварыг дуусгах технологийн шинэчлэл хийх зэрэг олон чухал зорилт хамаарч байна. Эдүгээ хил орчмын, бүс нутгийн хувийн капиталын оролцоотой Монгол, Оросын 170 орчим хамтарсан үйлдвэрийн газрууд бий болоод ажиллаж байна. Гаалийн татварын дарамтыг бууруулахад тустай худалдааны төвүүдийг нээхийг ихэд сонирхох болов. Чойбалсан хотод Читийн худалдааны төв нээгдэж, Улаанбаатарт Москва, Эрхүү, Улаан-Үдийн худалдааны төвүүд, Москва, Эрхүү, Улаан-Үдэд Улаанбаатарын худалдааны төвүүд байгуулагдан ажиллах болов. Монгол дахь Оросын экспортын 80 орчим хувь нь хил зэргэлдээ бүс нутагт оногдож байна.

1992 оны 6 дугаар сард Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим ба Оросын Холбооны худалдааны төлөөлөгчдийн газрын санаачилгаар Улаанбаатарт Монголын ба түүнтэй зэргэлдээх Оросын эдийн засгийн бүсүүдийн ажил хэрэгч хүрээнийхний төлөөлөгчдийн уулзалт зохион байгуулсан нь хоёр орны бүс нутгуудын болон аж ахуй эрхлэгч субъектуудын хоорондын харилцааг чанарын шинэ үндсэн дээр хөгжүүлэхэд чухал түлхэц өгсөн юм.

Монгол, Оросын бүс нутгууд, субъектуудын харилцаа, хамтын ажиллагаа өсөн өргөжих тутам уг харилцааны эрх зүйн үндэс, арга, механизмыг боловсронгуй болгох талаар ч ахиц гарч байна. Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын хүрээнд Монгол-Буриадын Засгийн газар хоорондын, Монгол-Якутын хоорондын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан техник, соёлын талаар хамтран ажиллах комиссууд байгуулсан ба ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллага болон Монгол Улсын орон нутгийн засаг захиргааны хоорондын хамтын ажиллагааны зарчмуудын тухай ОХУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2000 оны 11-р сард байгуулагдсан зэрэг нь тийм механизм, эрх зүйн үндсийг бүрдүүлэх чухал үйл явдал болов.

Харилцан бараа нийлүүлэх хямд төсөр, үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, хилийн шалган нэвтрүүлэх боомтуудыг тохижуулах, ажиллагааг нь тогтмолжуулах, цогцолборууд бий болгох, худалдааны чөлөөт бүс байгуулахад чиглэсэн ажлыг эрчимжүүлэх шаардлага улам

өсөв. 1995 оны эцсээр Монгол Улсын Их Хурал тус орны нутаг дэвсгэр дээр Эдийн засгийн чөлөөт бүс /ЭЗЧБ/ байгуулах үзэл баримтлал баталжээ. Түүнд энэ талаарх төрийн бодлогын хэтийн төлөв байдлыг тоймлон ЭЗЧБ-ийн зохион байгуулалтын ба ажиллах эрх зүй, эдийн засгийн ерөнхий үндсийг тодорхойлсон байна. Уг үзэл баримтлалын дотор ЭЗЧБ байгуулах тэргүүлэх бүс нутгийн нэрсийг тодорхойлсны дотор Оросын хилийн ойрх Хиагтаас холгүй орших Алтанбулагийг нэгдүгээр ээлжинд тавьсан юм. Үүний дараа УБТЗ-ын дагуух Дархан, Чойр мэт аж үйлдвэрийн төвүүд, Монгол Хятадын хил дээр орших төмөр замын Замын-Үүд-зангилаа, Өрнөдөд Тува, Алтайн хилийн ойролцоо, ОХ-ны баруун Сибирьтэй худалдаа хөгжүүлэх чиглэл бүхий Цагааннуурын дамжлага баазын сууринд тус тус байгуулахаар төлөвлөж байгаа ажээ. Энэхүү үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Их Хурал 1996 оны дундуур "Алтанбулаг"-эдийн засгийн чөлөөт бүсийн статусын хууль баталж, түүнийг хэрэгжүүлэх талаар Засгийн газрын хэд хэдэн тогтоол гарчээ. Нэлээд аажуу удаан үргэлжилсэн энэ ажил УИХ-ын 2002 оны хаврын чуулганаар баталсан Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын хуулийн үндсэн дээр бодитой хэрэгжих болов. Энэ нь хоёр улсын хоёр талын төдийгүй, олон талын гадаад эдийн засгийн харилцааны үр ашигтай, их ирээдүйтэй хүчин зүйл юм. Субъектуудын хамтран ажиллах сонирхлын хүрээг өргөтгөх, орон нутгийн чадавхид зохицсон, зах зээлийн хэрэгцээг тусгасан үйлдвэр, аж ахуйн газрууд байгуулах санаачлагыг өрнүүлэхийн зэрэгцээ хамтын ажиллагааныхаа хэтийн төлөвийг хөрш орнуудын интеграцийн чиг хандлагад нийцүүлэх нь бодит хэрэгцээ болжээ.

Хил орчмын харилцааг өргөтгөн гүнзгийрүүлэхэд хилийн дэг журмыг сахиулах, хил хязгаарын хэвийн нөхцөл байдлыг хангах явдал их үүрэгтэй юм. Монгол Улс, Оросын Холбооны Улс 1993 онд хилийн шугамаа хамтран шалгаж тодотгон, 1996 онд Монгол, Орос, Хятад гурван улсын хилийн баруун, зүүн уулзваруудын цэгийг тогтоосон протоколд Бээжин хотноо гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд 1998 оноос Монгол Улс, ОХУ-ын Элчин сайдын яамдад хилийн албан ёсны төлөөлөгчдийг харилцан суулгаж ажиллуулжээ. 1994 онд "Хилийн боомт болон Монгол Улс, ОХУ-ын хооронд улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдсан байна. Эдүгээ тус хоёр улсын хил дээр олон улсын зорчигч, ачаа тээврийн 4, хоёр талын зорчигч, ачаа тээврийн 9, түр буюу улирлын 9, дамжин өнгөрөөх зориулалттай 7 боомт тус тус

ажилладаг ажээ. 2000 оны 11 дүгээр сард хил орчмын хамтын ажиллагааны тухай ерөнхий хэлэлцээр байгуулж, хулгайлагдсан болон бэлчээрээр хил давсан малыг буцааж олгох комисс ажиллуулах ноот бичиг солилцсоны дагуу уг комиссууд ажиллаж эхлэв. 1987-2001 онд явуулсан Монгол, Оросын улсын хилийг шалгасан дүнгийн тухай баримт бичгийг баталсан тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн ноот бичигт 2002 оны 3 дугаар сард гарын үсэг зурж, түүнийг НҮБ-д бүртгүүлэхээр тохиролцжээ.

Эдгээр арга хэмжээнүүд нь Монгол, Оросын хил орчмын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх, иргэд харилцан нэвтрэх саад бэрхшээлийг багасгах, хилийн тодорхой хэсэгт гардаг зөрчил, малын хулгайг таслан зогсоох, хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжин идэвхжүүлэх таатай нөхцөл бүрдүүлэв.

Монгол, Оросын хамтын ажиллагаа шинжлэх ухаан, соёл боловсролын салбарт ч сэргэн аажим шинэчлэгдэж байна.

Монгол Улсын Засгийн газар ба ОХУ-ын Засгийн газрын хооронд 1995 оны 4 дүгээр сарын 5-нд Москва хотноо гарын үсэг зурсан соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн ач холбогдлыг онцлон үзэх хэрэгтэй. Хэлэлцээрт хоёр орны эрдэм шинжилгээний болон боловсролын байгууллагуудын хооронд шууд холбоо тогтоож хөгжүүлэх ба дэмжих зорилтыг онцлон анхаарсан байна. Сүүлийн жилүүдэд Монгол, Оросын холбогдох яам газруудын хооронд гэрээ, хэлэлцээр байгуулах замаар шинжлэх ухаан, хүмүүнлэгийн болон соёлын салбарт хамтран ажиллах гэрээ, эрхийн үндсийг бүрэлдүүлж чадсан гэж болно. Шинжлэх ухааны байгууллагуудын хооронд хэлэлцээр байгуулагдаж геологи, биологи, геофизик, түүх, соёлын зэрэг экспедицүүд ажиллаж ОШУА-ийн дадлагажих курс, аспирантур, докторантурт Монголын эрдэмтдийг хүлээн авч бэлтгэх, хоёр орны эрдэмтдийн хамтарсан эрдэм шинжилгээний хурал, симпозиум зохиож хамтын бүтээлүүд туурвих, Оросын эрдэмтэд ч Монголын шинжлэх ухааны байгууллагуудад доктор, дэд докторын зэрэг цол хамгаалдаг болов.

2000 оны эцсээр Эрхүүд Монголыг судлах төв байгуулагдаж, “Орос, Монгол олон туйлт ертөнцөд: мянганы зааг дахь хамтын ажиллагааны үр дүн, хэтийн төлөв”- сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал болов. Энэ нь шинжлэх ухааны салбарт хамтын бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх нэгэн шинэ механизмтай болсон хэрэг юм.

Монголд Оросын дээд сургуулиудын салбарууд байгуулагдан ажиллаж эхэлсэн нь манай хамтын ажиллагааны түүхэнд шинэ үйл явдал юм. ОХУ-ын их, дээд сургуулиудад 1996 оноос эхлэн монголоос жил тутам 60 хүртэл тооны оюутан, 30 хүртэл аспирант, докторант, мэргэжил дээшлүүлэгчдийг хүлээн авч бэлтгэж байгаа ба ОХУ-ын ерөнхийлөгчийн тэтгэлгээр жил бүр манай 130 орчим оюутан, аспирантыг элсүүлэн суралцуулах болжээ.

Одоо ОХУ-д манай 1000-аад оюутан, аспирант, докторант Засгийн газар хоорондын хэлэлцээр ба ОХУ-ын ерөнхийлөгчийн тэтгэлгээр суралцаж байна. Монгол Улсын их, дээд сургуулиудад суралцдаг ОХУ-ын оюутнуудын тоо ч өсөх болов.

Саяхан 2002 оны 9 дүгээр сард Монгол Улсын боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд А.Цанжид ОХУ-ын Боловсролын Яам хоорондын Гэрээнд" Москва хотноо гарын үсэг зурж хоёр улсын Засгийн газар хоорондын комиссын хүрээнд шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны дэд комиссын бүрэлдэхүүнийг ойрын хугацаанд шийдэж, комиссыг ажилд нь оруулах талаар тохиолцов. /15.2002.9.12/

Соёлын хамтын ажиллагаа баялаг уламжлалдаа түшиглэн хоёр орны төв, бүс нутгийн бүх хүрээг хамран жилээс жилд идэвхжин хөгжиж байна. Монгол Улс, ОХУ-ын янз бүрийн субъектуудын хооронд шууд харилцаа хөгжиж соёл, урлагийн хүрээнийхнийг өргөнөөр хамарсан соёлын өдрүүдийг харилцан зохиож, сонгодог урлаг, дуурийн театруудын хооронд жүжигчид солилцох, хамтарсан тоглолт зохион байгуулах, урлаг, соёлын ололтын үзэсгэлэн гаргах, харилцан сурталчлах зэргээр соёлын үнэт зүйлээ баяжуулах ажил зохиогдож байна.

Шинжлэх ухаан, боловсрол, соёлын салбар дахь өргөжиж буй харилцаа нь Монгол, Оросын бүх талын хамтын ажиллагааг улам хүмүүнлэг, оюунлаг агуулгатай болгож, орчин үеийн технологийн түвшинд хүргэх нэг хүчин зүйл мөн.

Монгол, Оросын харилцаа бүх хүрээнд, ялангуяа эдийн засгийн хүрээнд сэргэн идэвхжиж байгаагаас үзэхэд бидэнд шийдвэрлэж болшгүй асуудал байхгүй гэдэг нь харагдаж байна.

Манай харилцаанд шийдэгдээгүй гэгддэг нэгэн асуудал бол ЗХУ задарсны дараа үлдсэн Монголын өр гэгчид хамаарна. Монгол ба ЗХУ-ын харилцаа, Монгол ба ОХУ-ын өнөөгийн харилцааны шинж чанар, агуулга, чиглэл, хэмжээ, далайц, зорилт, үр дагавраар ч зарчмын ялгаатай.

Зөвлөлт Холбоот Улс, Монгол Улсын харилцаа нь: социалист интернационализм, социализм байгуулах нийтлэг зүй тогтол, социалист орнууд ойртон нягтрах, коммунизмд бараг нэгэн зэрэг жигдрэн орох зүй тогтол, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх цогцолбор программд дэвшигдсэн нийтлэг сонирхол, эрх ашиг гэгч нь Монголын үндэсний сонирхол, эрх ашгийн дээр тавигдаж, социалист орнуудын таван жилийн төлөвлөгөөг зохицуулах явцад Монгол нь өөрийн нөхцөл, бололцооноос давсан ачааллыг даахгүйд хүрч байв. Үүний хамт хоёр системийн сэргөлдөөнөөний дарамт социалист орнуудын удирдагчдын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээрүүд, удирдлагын дээд түвшинд гаргаж байсан шийдвэрүүд зэрэг эцсийн дүнд социализм байгуулалтыг хурдасгах гээд нуралтанд хүргэсэн улс төрийн нөхцөл шалтгааныг харгалзан үзвээс манай хоёр найрамдалт ард түмний сэтгэлийг зовоож байгаа улс төрийн зорилго шийдлээс үүдэлтэй “их өр” гэгчийг гагцхүү улс төрийн аргаар шийдвэрлэх нь зүйд нийцнэ гэж үзэж байна.

Монгол, Оросын ард түмний олон үеийн харилцааны явцад хуримтласан соёл иргэншлийн үнэт зүйлд тулгуурлан хөгжиж байгаа өнөөгийн ардчилсан шинэчлэлтийн үеийн харилцан итгэлцэл, харилцан шүтэлцээт түншлэлийн, адил тэгш байх түгээмэл зарчмаар төлөвшиж буй найрсаг хөршийн харилцаанд ЗХУ-ын үед үүссэн өр хэмээгч байнгын дарамт байх учиргүй. Үүний нэгэн адил ЗХУ-ын задарсны уршаар түүний техник, эдийн засгийн шууд хараат байсан олон арван үйлдвэр аж ахуйн газрууд зогсолтонд орсноос үүссэн Монгол улсын хохирлын тухай асуудал ч үүний нэгэн адил юм. ЗХУ-ын задрал, социалист хамтын нөхөрлөлийн уналтаас Монгол Улсын хөгжилд учруулсан удал даамжиран ужгирсан хохирол нь зээлийн өрийн хүүгээс ч илүү гүнзгийрэн үргэлжлэх уршиг тарьсан нь илэрхий байна. Үүнээс гадна эдийн засгийн агуулга нь тодорхой бус шилжих рубль гэгч орчин үеийн зах зээлд бодит байр эзлээгүй нэгжээр хэмжигдсэн их өр хэмээгчийн үнэлэмж хэмжээ нь ч тогтоогүй, арваад жил яриад шийдвэрлэх арга ч олоогүй хэвээр байна. Энэхүү их өр гэгчийн талаар ОХУ-ын Төрийн Думын орлогч дарга Венгеровский: бид хэн хэндээ төлөх өртэй гэж 1994 онд хэлж байсан /3.1994.12.7/ бол, Оросын Холбооны Улсын Засгийн газрын орлогч дарга, эдийн засгийн гадаад харилцааны дарга О.Д. Давыдов: “Монгол Улс өрийг бүгдийг хэзээ ч төлөхгүй гэдгийг бид сайн мэдэж байна. Монголын эдийн засагт өнөөдөр ийм чадавхи байхгүй учир өрийг бүгдийг барагдуул гэж ярих нь утгагүй

хэрэг” /З.1995.12:2/ гэж хэлсэн байдаг. Монголын ард түмэн түүхэндээ хамгийн их хөдөлмөрлөж, хүч чадлаа бүрэн дайчилж, итгэл дүүрэн бүтээн байгуулж, ЗХУ-тай “ах дүү” ёсоор хамтран зүтгэж, түүний бүх талын тусламжид түшиглэн, байгаа бүхнээ сэтгэл харамгүй хуваалцаж байсан чухам тэр он жилүүдэд эдүүгээгийн зарим хүний амнаас гардаг тоо шиг хэмжээлшгүй өрөнд унана гэдэгт үнэмших бэрх санагддаг юм. Бүр 1993 онд ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Ельцин Монгол Улсын Ерөнхийлөгчтэй уулзахдаа “ОХУ өмнөх үеийнхний алдааг одоо үүрэхгүй” гэж байсан бол Оросын өнөөгийн удирдагчид өрийн асуудлыг шийдэхдээ Монголын ард түмэнд дарамт үзүүлэхгүй, өр үүссэн өвөрмөц нөхцөлийг харгалзан үзнэ гэсэн байр суурьтай байна. Түүнийг Монголын эдийн засагт дарамт үзүүлэхгүйгээр шийднэ гэж Ерөнхийлөгч В.Путин хэлсэн. Энэ бүхэн уг өр гэгчийг гагцхүү улс төрийн аргаар ухаалгаар шийдвэрлэх нь зүйтэй гэдгийг харуулж байна.

Ингэхлээр өрийн тухай асуудал бол ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд ноён О.М.Дерковскийн хэлсэнчилэн “манай харилцааг тодорхойлох хэмжээний асуудал биш” болой. БНМАУ-ын ЗХУ-ын харилцааны явц, улс төр, эдийн засгийн бодлогоор бэлтгэгдэж амьдралаар нэгэнт няцаагдсан хуучин системийн гажуудалтай холбогдон лавширсан их өр” гэгчийг тэглэх нь аль аль талдаа халгүй санагдана.

Үнэхээр ч хуучин системийн уршиг, гажуудлаас үл хамааран Монгол, Оросын харилцаа эдүгээ хүрээгээ тэлж улам эрч хүч авч байна.

В.В.Путины айлчлалаас хойш нэг жил гаруйхан хугацаа өнгөрч байгаа хэдий ч Монгол, Оросын харилцаанд шинэ эрин үеийн шинэ шатны агуулгыг тусгасан дэвшил гарч буйг үйл явц харуулсаар байна. 2001 он бол “Улаанбаатарын Тунхаглалын үзэл санаа хэрэгжих гарааны жил болов. 2001 оны 3 дугаар сард Москвад Сталины аллагын золиос болон хэлмэгдсэн Монголын төр, Намын 33 зүтгэлтний дурсгалд зориулсан хөшөөг Бутовын оршуулгын газарт нээсэн нь хэлмэгдэгсдийн үйл хэрэг, нэр төрийг сэргээж хүндэтгэн мөнхжүүлсэн улс төрийн чухал арга хэмжээ болсон бөгөөд энэ талаар цаашдын алхмууд хийгдэх нь лавтай. 2001 оны 11 дүгээр сард Монголын гадаад харилцааны сайд С.Эрдэнэчулуун Москвад албан ёсны айлчлал хийж 2002-2003 онд хоёр орны гадаад харилцааны байгууллагууд хамтран ажиллах Протоколд гарын үсэг зурсан, мөн хоёр улсын хооронд найрамдалт харилцаа тогтоосон анхны хэлэлцээрийн 80 жилийн ойг хоёр талд ёслон тэмдэглэсэн хийгээд 2002 оны эхээр Улсын Их Хурлын дарга

С.Төмөр-Очир тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-д айлчилсан зэрэг нь манай харилцалаг улс төрийн хүрээнд идэвхжүүлсэн үйл явдлууд байв.

Эдийн засгийн хүрээнд Монгол Улс ба Эрхүү, Кемеров, Чит мужууд Буриад, Алтай, Тува зэрэг БН Улсуудын хооронд худалдаа, үйлдвэрлэлийн чиглэлээр олон арван хэлэлцээр байгуулагдаж, бүс хоорондын “Сибирийн хэлэлцээр” нийгэмлэгтэй холбоо тогтож, Улаанбаатар, Москвагийн хооронд 2002-2004 онд хамтран ажиллах Программ боловсрогдов. Монголоос мах нийлүүлэх хэмжээ өсөв. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны засгийн газар хоорондын олкомисс болон салбар комиссуудын үйл ажиллагаа мэдэгдэхүйц идэвхжив.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын урилгаар 2002 оны 3 дугаар сарын 25-26-нд ОХУ-ын Ерөнхий сайд М.М.Касьяновын Монголд хийсэн айлчлал хөрш хоёр орны харилцаанд шинэ түлхэц өгсөн том алхам болов. Энэ үеэр ОХУ-ын ерөнхийлөгч В.Путины 2000 онд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын дүнд олон чиглэлд сэргэн идэвхжсэн Монгол Оросын харилцаа, хамтын ажиллагааны тулгамдсан асуудлуудад хариу өгч, хэд хэдэн чухал хэлэлцээр, ноот бичиг, протокол, санамж бичгүүдэд гарын үсэг зурсан байна. Ерөнхий сайд нар худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх үлэмж нөөц бололцоо байгааг онцлоод Худалдааг чөлөөтэй болгон өргөтгөх, Гаалийн татварын түвшинг тэгштгэх, экспортын барааны тээврийн татварыг багасгах, эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хоёр жилийн төлөвлөгөө зохиох, өрийн асуудлыг үүссэн онцлог нөхцөлийг харгалзан зохицуулах, хамтарсан үйлдвэрийн газруудад тэргүүн ээлжинд “Эрдэнэт”, Монголроссветмет”, “Улаанбаатар төмөр зам”-д шинэчлэл хийх, үр ашгийг дээшлүүлэх нь чухал гэж үзэв. Мөн өмчийн шинэ хэлбэрийн үндсэн дээр хамтарсан үйлдвэр байгуулах, харилцан хөрөнгө оруулалт хийх, шингэрүүдсэн хий боловсруулах үйлдвэрийг Монголд байгуулах, 340 айлын орон сууцны “Москва” цогцолборыг Улаанбаатарт байгуулах, Монголын мянганы зам байгуулахад Оросын барилгачдыг оролцуулах, мөнгө, холимог металл олборлох, ирээдүй бүхий нүүрсний орд газруудыг ашиглах, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах хөтөлбөр боловсруулах зэрэг өргөн хүрээтэй тохиролцоонд хүрсэн байна.

ОХУ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Монгол Улстай харилцаатай болон хил залгаа БН Улсууд, муж, бүс нутгийн удирдлагууд оролцон ирсэн нь манай аймаг, бүс нутгуудтай хамтран ажиллах, тухайлбал “мянганы зам”-ын бүтээн байгуулалтад оролцох, мах боловсруулах, хивсний үйлдвэрийн чиглэлээр хамтран ажиллах тус тусын сонирхол, боломжийг илэрхийлэн ярилцжээ. Мөн оюутан сургахад дэмжлэг үзүүлэх хүрээг өргөтгөх боломжтой гэж үзсэн байна. Ерөнхий сайд нар ч бүс нутаг, субъектууд, хил орчмын хамтын ажиллагааг улам идэвхжүүлэхэд их ач холбогдол өгсөн байна. Энэ оны 9 дүгээр сард манай дэд бүтцийн сайдын урилгаар ОХУ-ын БН Алтай Улсын Засгийн газрын тэргүүн М.И.Лапшин Монголд айлчилж Асгатын мөнгөний ордыг эзэмшихэд хөрөнгө оруулалт хийх “Мянганы замын бүтээн байгуулалтанд оролцох, Алтай улсын их сургуульд Монголын оюутнуудыг сургах, Монгол, Оросын соёлын наадам зохион байгуулах зэрэг тодорхой ажил хэрэгч хэлэлцээ хийж тэдгээрийг бодитой хэрэгжүүлэх талаар тууштай ажиллахаар тохиролцсон нь тийм хамтын ажиллагааны бас нэг шинэ нотолгоо болов. Монгол, Орос, Хятадын харилцаа, стратегийн түншлэлээс багагүй хамааралтай болох нь хий, нефть дамжуулах хоолойг барих асуудал дээр харагдаж байв. Энэ талаар интеграцид оролцох боломжийн арга зам хайх нь чухал юм. Монгол Улсын идэвхтэй, нээлттэй бодлого, хүч чармайлт нь хөрш орнуудын эрх ашиг, нийтлэг сонирхолд нийцэхийн хэрээр манай орнуудын хамтын ажиллагааг бүх хүрээнд идэвхжүүлэх чухал хүчин зүйл болж байна. “Мянганы зам”, “Худалдаа, Эдийн засгийн чөлөөт бүс” мэт ирээдүйтэй холбогч шижмүүд үүсч байна.

Монгол, Оросын сайн хөршийн найрсаг харилцааг бүрэн итгэлцэлд тулгуурлан хөгжүүлэх харилцан хамаарал, хүч чадавхи, шинэ боломж нийгмийн амьдралын бүх хүрээнд нээгдсээр байгаа нь XXI зуунд манай хамтын ажиллагаа эрчимтэйгээр ахин урагшлах төлөвийг тодорхойлж улмаар АНД, ЗХА-ийн бүс нутаг болон дэлхий дахины нийтлэг үйл явцын чиг хангдлагад нийцэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын үндсэн хууль. УБ. 1992 он.
2. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УБ. 1994 он
3. "Ардын эрх" сонин.
4. Монгол Улс, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаан тухай гэрээ.
5. "Засгийн газрын мэдээ" сонин. 1993 оны 2-р сар. №5.
6. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ. 1994 он.
7. Концепция Внешней политик Российской Федерации / "Международная жизнь" - журнал. 8-9.2000/
8. Россия и Монголия. Новый взгляд на историю взаимоотношений в XX веке. Москва. ИВ РАН 2001.
9. "Проблемы Дальнего Востока". Журнал. 2001. №1.
10. Монголын тусгаар тогтнол ба Орос, Хятадын хүчин зүйл. УБ. 1999.
11. Российский Дальний восток и северо-восточная Азия. Москва. 1998.
12. Геополитика современности и геостратегия России. Москва. 1996.
13. Б.Лхамсүрэн. Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол. УБ. 1995.
14. "Мировая экономика и международные отношения" Журнал. 2001.
15. "Үнэн" сонин.